



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 1 сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/071-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)  
Архангай аймаг  
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа  
Утас: 7033-3141  
Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар  
Утас: 7033-2860  
Цахим хаяг: [Nerquibaatar@audit.gov.mn](mailto:Nerquibaatar@audit.gov.mn)

Гэрээгээр аудит гүйцэтгэсэн  
Бизкон аудит ХХК Архангай аймаг дахь салбар  
Ахлах аудитор Ч.Анхбаяр  
Утас: 8511-6555  
Цахим хаяг: [ankha964@gmail.com](mailto:ankha964@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	10
5.1 Албан шаардлага .....	10
5.2 Зөвлөмж.....	10
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	11

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БГАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arhangai@audit.gov.mn

2025.02.25 № 66

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар-сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Ерөнхий боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 5,271,349.5 мянган төгрөг, урсгал санхүүжилт орон нутгаас 698,943.6 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 262,458.4 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 34,057.4 мянган төгрөг, нийт 6,267,272.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, төсвийн зардлын нийт гүйцэтгэлээр 5,661,948.8 мянган төгрөг буюу 90,34 хувьтай зарцуулж, төрийн сангийн дансанд 615,079.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 үндсэн зорилтын хүрээнд 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн БШУГ-аас 96.0 хувьтай үнэлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>760,638,048.23</b>	<b>1,057,542,511.21</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	268,389,417.53	615,079,581.45
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	268,389,417.53	615,079,581.45
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	268,389,417.53	615,079,581.45
31211	Төрийн сангийн харилцах	268,389,417.53	615,079,581.45
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	542,398.11	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	542,398.11	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	491,706,232.59	442,462,929.76
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	52,781,027.63	56,327,724.63
35110	Тусгай зориулалттай материал	50,537,927.63	54,351,376.63
35130	Эм боох материал	2,243,100.00	1,976,348.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	418,675,204.96	372,405,205.13
35410	Бичиг хэргийн материал	8,743,690.00	5,350,910.00
35420	Аж ахуйн материал	349,389,004.96	316,026,435.13
35440	Түлш, шатах тослох материал	-	250,000.00
35450	Барилгын засварын материал	50,777,860.00	50,777,860.00
35460	Хүнсний материал	9,764,650.00	-
35600	Мал амьтад	20,250,000.00	13,730,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,822,695,463.50</b>	<b>8,210,703,749.84</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,822,695,463.50	8,210,703,749.84
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,417,449,103.34	7,803,451,194.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,866,788,744.34	7,265,097,876.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	-398,837,382.24	-522,759,634.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,100,091.00	100,100,091.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-59,781,998.72	-76,465,347.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	853,477,251.70	955,122,455.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-276,418,544.74	-270,844,314.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	326,906,306.10	338,230,380.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-131,867,887.85	-123,038,377.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	66,047,235.00	66,047,235.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-18,911,582.40	-27,537,915.36
39217	Ном	89,946,871.15	99,498,745.54
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	405,246,360.16	407,252,555.16
39301	Програм хангамж	12,375,220.00	24,725,220.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-668,859.84	-11,012,664.84
39303	Бусад биет бус хөрөнгө	393,540,000.00	393,540,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>8,583,333,511.73</b>	<b>9,268,246,261.05</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>9,118,900.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	9,118,900.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	9,118,900.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	9,118,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	9,118,900.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,583,333,511.73</b>	<b>9,259,127,361.05</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	8,583,333,511.73	9,259,127,361.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,838,224,779.81	1,838,224,779.81
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	4,129,271,550.83	4,805,065,400.15
51210	Өмнөх үеийн үр дүн	4,129,271,550.83	4,129,271,550.83
51220	Тайлант үеийн үр дүн	-	675,793,849.32
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,615,837,181.09	2,615,837,181.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>8,583,333,511.73</b>	<b>9,268,246,261.05</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>6,300,034,703.17</b>	<b>6,589,698,208.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>978,039,503.17</b>	<b>619,405,108.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	978,039,503.17	619,405,108.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,983,700.00	38,345,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,919,200.00	11,057,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,064,500.00	27,288,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	826,564,089.00	568,055,759.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	55,491,714.17	13,003,449.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,321,995,200.00</b>	<b>5,970,293,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,417,194,900.00	5,271,349,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,417,194,900.00	5,271,349,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	904,800,300.00	698,943,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	904,800,300.00	698,943,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,289,531,493.90</b>	<b>5,892,753,651.44</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,289,531,493.90</b>	<b>5,892,753,651.44</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,926,289,223.94	5,618,911,020.73
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,198,880,313.18	3,709,548,947.24
210101	Үндсэн цалин	1,978,050,718.18	2,506,607,509.40
210102	Нэмэгдэл	1,082,790,971.00	1,028,199,127.84
210104	Урамшуулал	138,038,624.00	174,742,310.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	401,900,138.52	464,226,173.56
210201	Тэтгэврийн даатгал	275,917,788.45	319,870,622.97
210202	Тэтгэмжийн даатгал	32,453,631.40	37,129,267.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,729,705.13	18,895,179.73
210204	Ажилгүйдлийн даатгал	6,163,541.62	17,666,220.92
210205	Эрүүл мэндийн даатгал	61,635,471.92	70,664,882.09
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	643,609,200.04	657,671,419.29
210301	Гэрэл, цахилгаан	40,081,526.64	43,279,636.00
210302	Түлш, халаалт	494,395,802.00	494,579,346.00
210303	Цэвэр, бохир ус	109,131,871.40	119,812,437.29
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,233,789.00	100,783,844.83
210402	Тээвэр, шатахуун	-	2,284,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	10,659,050.00
210408	Бараа материал акталсны зардал	50,233,789.00	87,840,794.83
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	97,717,980.00	124,989,415.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	738,315.00
210502	Хоол, хүнс	97,717,980.00	124,251,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	86,297,600.00	24,754,740.00
210604	Урсгал засвар	86,297,600.00	24,754,740.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	24,270,953.22	59,938,562.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,979,500.00	11,057,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,291,453.22	48,881,162.39
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	423,379,249.98	476,997,918.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,089,977.44	88,580,428.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,348,950.00	33,165,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	320,940,322.54	355,252,490.42
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	363,242,269.96	273,842,630.71
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	250,446,870.00	242,403,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	217,608,270.00	242,403,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,838,600.00	-

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	112,795,399.96	31,439,030.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	112,795,399.96	31,439,030.71
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,010,503,209.27</b>	<b>696,944,556.56</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	-21,150,707.24
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		- 21,150,707.24
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	- 21,150,707.24
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,010,503,209.27</b>	<b>675,793,849.32</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>5,417,978,900.00</b>	<b>6,008,639,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>95,983,700.00</b>	<b>38,345,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	95,983,700.00	38,345,900.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	95,983,700.00	38,345,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,919,200.00	11,057,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,064,500.00	27,288,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,321,995,200.00</b>	<b>5,970,293,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	4,417,194,900.00	5,271,349,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,417,194,900.00	5,271,349,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	904,800,300.00	698,943,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	904,800,300.00	698,943,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>5,000,916,680.47</b>	<b>5,465,593,111.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,000,916,680.47</b>	<b>5,465,593,111.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,629,285,150.51</b>	<b>5,199,235,360.37</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	3,199,569,265.18	3,708,805,399.56
210101	Үндсэн цалин	1,941,719,453.76	2,510,456,071.46
210102	Нэмэгдэл	1,121,687,122.42	1,026,931,116.98
210104	Урамшуулал	136,162,689.00	171,418,211.12
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	401,753,584.63	464,405,523.13
210201	Тэтгэврийн даатгал	274,231,435.66	324,807,837.57
210202	Тэтгэмжийн даатгал	32,231,886.43	37,037,444.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	25,749,707.20	18,659,773.08
210204	Ажилгүйдлийн даатгал	6,282,082.07	17,668,857.75
210205	Эрүүл мэндийн даатгал	63,258,473.27	66,231,610.69
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	643,609,200.04	657,671,419.29
210301	Гэрэл, цахилгаан	40,081,526.64	43,279,636.00
210302	Түлш, халаалт	494,395,802.00	494,579,346.00
210303	Цэвэр, бохир ус	109,131,871.40	119,812,437.29
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	99,093,370.00	121,993,130.00
210502	Хоол, хүнс	99,093,370.00	121,993,130.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	118,955,700.00	9,833,150.00
210604	Урсгал засвар	118,955,700.00	9,833,150.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	25,249,953.22	61,898,562.39
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,979,500.00	11,057,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,270,453.22	50,841,162.39
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	141,054,077.44	174,628,176.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	103,235,327.44	143,843,276.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	37,818,750.00	30,784,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>371,631,529.96</b>	<b>266,357,750.71</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	258,836,130.00	234,918,720.00

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2024 оны  
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	225,997,530.00	234,918,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,838,600.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	112,795,399.96	31,439,030.71
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	112,795,399.96	31,439,030.71
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>417,062,219.53</b>	<b>543,045,888.92</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>181,703,000.00</b>	<b>196,355,725.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>181,703,000.00</b>	<b>196,355,725.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	181,703,000.00	196,355,725.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	181,703,000.00	196,355,725.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-181,703,000.00</b>	<b>-196,355,725.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	235,359,219.53	346,690,163.92
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		268,389,417.53
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	268,389,417.53	615,079,581.45

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,838,224,779.81	2,615,837,181.09	4,129,271,550.83	8,583,333,511.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,838,224,779.81	2,615,837,181.09	4,129,271,550.83	8,583,333,511.73
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	675,793,849.32	675,793,849.32
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,838,224,779.81	2,615,837,181.09	4,805,065,400.15	9,259,127,361.05

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	6,267,272,500.00	5,661,949,038.08	605,323,461.92	90.3
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,267,272,500.00	5,468,023,111.08	799,249,388.92	87.2
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,005,447,300.00	5,201,665,360.37	803,781,939.63	86.6
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,167,169,200.00	3,708,805,399.56	458,363,800.44	89.0
210101	Үндсэн цалин	2,809,241,400.00	2,510,456,071.46	298,785,328.54	89.4
210102	Нэмэгдэл	1,237,791,000.00	1,026,931,116.98	210,859,883.02	83.0
210104	Урамшуулал	120,136,800.00	171,418,211.12	-51,281,411.12	142.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	520,896,100.00	464,405,523.13	56,490,576.87	89.2
210201	Тэтгэврийн даатгал	354,209,400.00	324,807,837.57	29,401,562.43	91.7
210202	Тэтгэмжийн даатгал	41,671,700.00	37,037,444.04	4,634,255.96	88.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,835,800.00	18,659,773.08	2,176,026.92	89.6
210204	Ажилгүйдлийн даатгал	20,835,800.00	17,668,857.75	3,166,942.25	84.8
210205	Эрүүл мэндийн даатгал	83,343,400.00	66,231,610.69	17,111,789.31	79.5

**Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	688,943,600.00	657,671,419.29	31,272,180.71	95.5
210301	Гэрэл, цахилгаан	63,304,000.00	43,279,636.00	20,024,364.00	68.4
210302	Түлш, халаалт	494,241,700.00	494,579,346.00	-337,646.00	100.1
210303	Цэвэр, бохир ус	131,397,900.00	119,812,437.29	11,585,462.71	91.2
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	134,790,000.00	121,993,130.00	12,796,870.00	90.5
210502	Хоол, хүнс	134,790,000.00	121,993,130.00	12,796,870.00	90.5
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00	9,833,150.00	166,850.00	98.3
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,833,150.00	166,850.00	98.3
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	129,809,600.00	61,898,562.39	67,911,037.61	47.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,521,000.00	11,057,400.00	463,600.00	96.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	118,288,600.00	50,841,162.39	67,447,437.61	43.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	353,838,800.00	177,058,176.00	176,780,624.00	50.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	298,923,400.00	146,273,276.00	152,650,124.00	48.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,915,400.00	30,784,900.00	24,130,500.00	56.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	261,825,200.00	266,357,750.71	-4,532,550.71	101.7
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	261,825,200.00	266,357,750.71	4,532,550.71	101.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	261,825,200.00	234,918,720.00	26,906,480.00	89.7
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		31,439,030.71	-31,439,030.71	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>193,925,927.00</b>	-193,925,927.00	
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	193,925,927.00	-193,925,927.00	
224001	Дотоод эх үүсвэрээр		-193,925,725.00	193,925,725.00	
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	6,267,272,500.00	6,271,097,400.00	-3,824,900.00	100.1
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	5,271,349,500.00	5,271,349,500.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,271,349,500.00	5,271,349,500.00	-	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	698,943,600.00	698,943,600.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	698,943,600.00	698,943,600.00	-	100.0
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	296,979,400.00	300,804,300.00	-3,824,900.00	101.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,521,000.00	11,057,400.00	463,600.00	96.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,000,000.00	27,288,500.00	-4,288,500.00	118.6
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	262,458,400.00	262,458,400.00	-	100.0
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>268,389,417.53</b>	-268,389,417.53	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>615,079,581.45</b>	-615,079,581.45	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	155	155	-	100.0
620001	Удирдах ажилтан	4	4	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	116	116	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	35	35	-	100.0
<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1757	1757	-	100.0
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	1757	1757	-	100.0

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй.

Аудитаар нийт 112,137.6 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 9,118.9 мянган төгрөг, материаллаг бус алдаа зөрчил нь 112,137.6 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 43,870.6 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

5.1.2 Тайлант жилд 9,118.9 мянган төгрөгийн өглөг үүсгэж ажилласан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж, хууль тогтоомжид заасан холбогдох арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлээ.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авах ажиллагаатай холбоотой.

Илрүүлэлт: Тайлант онд 103,018.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд гэрээгээр худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.1.Захиалагч тендер шалгаруулалтыг энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан аргаар зохион байгуулна., 34 дүгээр зүйлийн 34.1-д "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно."48.2.1.худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан хуульд заасан хугацаанд зохион байгуулах; Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын 2-д "Энэ тогтоолын хавсралтаар тогтоосон төсөвт өртгийн дээд хязгаарыг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах захиалагч нарт, ... даалгасугай" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгссөн зөвлөмж: Бараа, материал, үндсэн хөрөнгө худалдан авахаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг мөрдөж худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулах арга хэмжээг авч биелэлтийг хангаж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 03 дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.  
дугаарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шууд гэрээгээр худалдан авалт хийсэн	1	0					1	0				
Өглөг үүсгэсэн	1	9,118.9			1	9,118.9						
Дүн	2	9,118.9			1	9,118.9	1	0				